



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 1121

Шивээговь сум

Сар шинийн баярын хүндэтгэлийн арга
 хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. XVII жарны Үзэсгэлэн болгогч хэмээх Усан туулай жилийн Сар шинийн баярыг тохиолдуулан сумын ахмадуудад хүндэтгэл үзүүлж, сар шинийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд 1,773,600 (нэг сая долоон зуун далан гурван мянга зургаан зуу) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Сар шинийн баярын хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Б.Алтансүх

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Д.Сэлэнгээ

(Нягтлан бодогч)

Б.Энхцэцэг

(Нярав)

Нарийн бичгийн дарга:

М.Гантуяа

(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

3. Сар шинийн баярын хүндэтгэлийн арга хэмжээнд зарцуулагдах зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

4. Тус арга хэмжээнд зарцуулагдах 1,773,600 (нэг сая долоон зуун далан гурван мянга зургаан зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын

дагуу гаргахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа), нягтлан бодогч (Д.Сэлэнгээ) нарт зөвшөөрсүгэй.


5.Тус ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, чанартай зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа), Нийгмийн бодлогын мэргэжилтэн (Б.Алтансүх) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

Сумын Засаг даргын 2023 оны 02-р сарын
14-ний өдрийн 114 дугаар
захирамжийн хавсралт



Сар шинийн баярын хүндэтгэлийн арга хэмжээнд
зарцуулагдах төсөв

2023.02.11

№	Материалын нэрс	Хэмжих нэгж ширхэг	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Хэвийн боов	ширхэг	5000	46	230000
2	Чихэр	кг	28000	3	84000
3	Хорхой ааруул	кг	30000	5	150000
4	Айраг	литр	7000	100	700000
5	Ууц		350000	1	350000
6	Бусад хүнсний бүтээгдэхүүнүүд	кг			259,600
Нийт дүн: 1,773,600					